



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Партизаны гудамж, Утас: 26 35 64, Факс: (976-11) 32 49 77,
И-мэйл: doc@nema.gov.mn, Вэбсайт: www.nema.gov.mn

2021.03.09 № 2/435

танай _____-ны № _____-т

**ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,
ЗАХИРАГЧ НАРТ**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврыг хүргүүлж байна.

Албан даалгаврын хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг хавсралт хүснэгтийн дагуу гарган, 2021 оны 6 дугаар сарын 04, 11 дүгээр сарын 12-ны өдрийн дотор тус тус Гал түймэртэй тэмцэх газарт ирүүлэхийг мэдэгдье.

Жич: Холбогдох мэдээллийг Гал түймэртэй тэмцэх газрын мэргэжилтэн, хошууч Э.Энх-Амгалангаас тодруулна уу. Утас: 93111104, 263551. Цахим шуудангийн хаяг: “untraahheltes@yahoo.com”, Skype: “OBEG gal tuimertei temtseh gazar” хаягаар ирүүлнэ.

Хавсралт 1 хуудастай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧУЛТЭМСҮРЭН



00000673



**ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай**

Улсын хэмжээнд 2020 онд Улаанбаатар хот, Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 15 аймгийн 74 суманд нийт 142 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч, 245.311 га талбай өртөж, экологийн хохирол 3 тэрбум, эд материал 41.1 сая, түймрийг унтраахад 145.4 сая төгрөг зарцуулж, нийт 3.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Оросын Холбооны Улсаас нийт 4 удаагийн хээрийн гал түймэр Монгол Улсын хилийг даван орж ирж, 3933 га хээрийн талбай гал түймэрт өртсөн. БНХАУ-ын хилийг давж 1 удаа, ОХУ-ын хилийг давж 1 удаа, нийт 2 удаагийн хээрийн гал түймэр Монгол Улсын хилийг давж гарсан байна.

Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллээр 2021 оны 3, 4 дүгээр сард агаарын температур Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Дорнод Монголын тал нутгаар олон жилийн дунджаас 1-1.5 градусаар илүү дулаан, 3, 4 дүгээр саруудад олон жилийн дунджаас бага хур тунадастай, нийт нутгаар хуурайшилтын зэрэг өндөр байх мэдээлэл ирүүлсэн.

Иймд 2021 онд Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. Covid-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий шаардлага. MNS ISO/PAS 45005:2021 стандарт, мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж Улсын Онцгой комиссын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Бүсийн төв болон төв, орон нутгийн

Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт

1.1. Ойн тухай хуулийн 17, 18, 26 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, төсвийг бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг тайланд тусгахыг,

1.2. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, 10.2.4, 10.3 дугаар зүйлд заасны дагуу орон нутагт байгуулагдсан "Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг"-т тодотгол хийх, гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр эрсдэл ихтэй үнэлэгдсэн сум, хороонд нэмэлт хэсэг байгуулахыг,

1.3. Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахлын тархалттай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөг болгон хүн хүч,

00000036

техник хэрэгслийг дайчилж ой, хээрийн гал түймэр гарсан тохиолдолд тухай бүр шуурхай унтраах арга хэмжээг зохион байгуулах,

1.4. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалаар батлагдсан зааврын дагуу Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд тодотгол хийхийг,

1.5. Бүсийн төвийн захирагч нар Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 6 дугаар 14-ний өдрийн 51 дүгээр тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын бүсийн төвийн ажиллах журам"-ын 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэн бүсийн хэмжээнд ой, хээрийн гал түймэртэй тэмцэх албаны бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд харьяа Онцгой байдлын газруудыг нэгдсэн удирдлагаар хангах, хүч хэрэгслийг дайчлан гаргахыг,

1.6. Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахалтай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах үйл ажиллагааг төлөвлөх, сургалт сурталчилгаа явуулах, дадлага сургалтыг аймаг, нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоотой хамтран танхимаар болон цахимаар зохион байгуулахыг,

1.7. Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 5 дугаар бүлгийн 3.3, 3.5-т заасныг хэрэгжүүлэн төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгээр оруулж, хачигт халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулах тарилгад хамруулахыг,

1.8. Нисгэгчгүй нисдэг төхөөрөмжийг ашиглах дадлага сургалтыг зохион байгуулж ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд тогтмол ашиглахыг,

1.9. Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, аялал жуулчлалын бааз зэрэг үйлчилгээний байгууллагуудад төлөвлөгөөт бус гал түймрийн улсын хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, ой, хээрийн гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулахыг,

1.10. Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүн, дайчлагдан ажиллах иргэдийн хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, автомашин, техник, тоног төхөөрөмж, бүх төрлийн багаж хэрэгслийн засвар үйлчилгээг хийж, аюулгүй найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэхийг,

1.11. Ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллах 1 бүлгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан офицероор ахлуулж, үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг байршил тодорхойлогч /GPS/, сансрын холбооны утас /IRIDIUM/ болон байр зүйн зургаар хангахыг,

1.12. Ой, хээрийн гал түймрийн мэдээ, мэдээллийг хүлээн авсан албан тушаалтан болон шуурхай удирдлагын оператор цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газарт цаг алдалгүй шуурхай мэдээлэхийг,

1.13. Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албатай хамтран ажиллах төлөвлөгөөнд заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн талаарх дуудлага, баримт, мэдээллийг хүлээн авсан тухай бүр төв, орон нутгийн Цагдаагийн байгууллагад мэдэгдэн харилцан мэдээлэл солилцож хэргийн газрын үзлэгт холбогдох мэргэжилтэн, алба хаагчдыг томилж ажиллуулах.

1.14. Хуурайшилт бүхий цаг хугацаа буюу 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд болон зуны хэт халалтын үед орон нутгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр эрсдэл ихтэй үнэлэгдсэн бүс нутагт орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран байнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэг ажиллуулахыг,

1.15. Төв, орон нутгийн телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчныг ашиглан хавар, намрын хуурайшилтын болон зуны хэт халалтын үед иргэд, олон нийтэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр сэрэмжлүүлэг, сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулахыг.

Хоёр. Үндэсний аврах бригадын захирагчид

2.1. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. Covid-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий шаардлага. MNS ISO/PAS 45005:2021 стандарт, мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөг болгон алба хаагчдад ой, хээрийн гал түймэр унтраах сургалт, дадлагыг /танхим, цахимаар болон хээрийн дадлага хэлбэрээр/ зохион байгуулахыг,

2.2. Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүний болон багаж хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, шүхрийн зааварлагч, шүхэрчин гал сөнөөгчдийн шүхрийн буултын дадлагыг зохион байгуулахыг,

2.3. Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 5 дугаар бүлгийн 3.3, 3.5-т заасныг хэрэгжүүлэн алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгээр оруулж, хачигт халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулах тарилгад хамруулахыг,

2.4. Нисгэгчгүй нисдэг төхөөрөмжийг ашиглах дадлага сургалтыг зохион байгуулж ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд тогтмол ашиглахыг,

Гурав. Ар талын 115 дугаар ангийн захирагчид

3.1. Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн 5 дугаар бүлгийн 3.3, 3.5-т заасныг хэрэгжүүлэн алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгээр оруулж, хачигт халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулах тарилгад хамруулахыг,

3.2. Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хүрэлцэн очих үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн сургалт, дадлагыг /танхим, цахимаар болон хээрийн дадлага хэлбэрээр/ зохион байгуулахыг,

3.3. Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх жолооч болон автомашин техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, засвар үйлчилгээг тогтмол хийж, шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, шатах, тослох материалын нөөц бүрдүүлэхийг.

Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг Гал түймэртэй тэмцэх газарт 6 дугаар сарын 04, 11 дүгээр сарын 12-ны өдрийн дотор тус тус ирүүлэхийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ  Г.АРИУНБУЯН

ОБЕГ-ЫН ДАРГЫН 2021 ОНЫ 3 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН 02 АЛБАН ДААЛГАВРЫН ХҮРЭЭНД ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГААС ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАНГИЙН ХҮСНЭГТ

д/д	Асуулт	Аймгийн нэр
1	Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан төсөв /мөнгөн дүн/	
2	Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан гамшгаас хамгаалах төлөвлөгөөний ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд тодотгол хийсэн тоо	
3	Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн байдал /үнэлгээний тоо/	
4	Эрүүл мэндийн үзлэгээр хамруулсан алба хаагчийн тоо	
5	Хачигт халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулах тарилгад хамруулсан алба хаагчийн тоо	
6	Нисгэгчгүй нисдэг төхөөрөмжийг ашиглах дадлага сургалтад хамрагдсан алба хаагчийн тоо	
7	Хяналт шалгалтын тоо	Шалгасан объектын тоо
		Илрүүлсэн зөрчил
		Арилгуулсан зөрчил
8	Хүргүүлсэн эрх зүйн баримт, бичиг	Мэдэгдэл
		ЗБАШ
		Танилцуулга
		Үйл ажиллагаа зогсоох тухай санал
9	Шийтгэл оногдуулсан талаар	Хуулийн этгээдийн тоо
		Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан мөнгөн дүн
		Иргэний тоо
		Иргэнд оногдуулсан мөнгөн дүн
10	Хяналтын цэг, эргүүл ажиллуулсан талаар	Сумын тоо
		Цэгийн тоо
		Ажилласан өдөр
		Ажилласан хүн
		Ажилласан техник
11	Сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулсан талаар	Сайн дурын хэсгийн тоо
		Танхимаар /цаг/
		Цахимаар /цаг/
		Дадлага сургууль /цаг/
12	ААНБ-д зохион байгуулсан сургалт	ААНБ-ын тоо
		Танхимаар /цаг/
		Цахимаар /цаг/
		Дадлага сургууль /цаг/
13	Иргэдэд сургалт зохион байгуулсан талаар	Иргэний тоо
		Танхимаар /цаг/
		Цахимаар /цаг/
		Дадлага сургууль /цаг/
14	Шинээр худалдан авалт хийсэн автомашин, техник, багаж хэрэгсэл	ОБЕГ-аас /мөнгөн дүн/
		Орон нутгийн хөрөнгө оруулалтаар /мөнгөн дүн/
		Сайн дурын хэсэг байгуулсан сумын тоо
15	Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн судалгаа	Хүний тоо
		Автомашин тоо
		Хэдэн удаа
16	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг хүргүүлсэн талаар	Хугацаа /цаг/
17	Гарын авлага тараасан талаар	Тоо
		мөнгөн дүн